

БАТЛАВ, УВС АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

/Д. БАТСАЙХАН/

2019 он 4 сар 12 өдөр

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ,  
ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ,  
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2019.03.03

Байшинт

Энэхүү гэрээг нэг талаас Увс аймаг(нийслэл) Бөхмөрөн сум (дүүрэг)-ын Засаг дарга Т.Төртогтох (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Хотгор ХХК (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 03-р сарын 03-ны өдөр Увс аймаг (нийслэл) Бөхмөрөн сум (дүүрэг)-нд байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү гэрээ нь Увс аймаг Бөхмөрөн сум (дүүрэг)-ын Хар алтат багийн нутагт Ашигт малтмалыг тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

**Хоёр. Засаг даргын эрх, үүрэг**

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах :

2.1.2. гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах :

2.1.3. энэхүү гэрээний хэрэгжилтэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймаг (сум, дүүрэг)-ийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх

боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх:

2.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах :

2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих :

2.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх .

### **Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх:

3.1.2. орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах :

3.1.3. хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах :

3.1.4. нийт ажлын байрны .... доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах :

3.1.5. өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх:


3.1.6. хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум, дүүрэг) –ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх :

3.1.7. бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох :

3.1.8. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах:

3.1.9. гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

## Дөрөв. Хамтын ажиллагааны хороо



4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

## Тав. Гэрээний хэрэгжилт

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг (сум, дүүрэг)-ийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

## Зургаа . Гэрээний хариуцлага

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи , уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

## Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

### Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

Хамтын ажиллагааны хорооны бүх гишүүдийн 2019 оны 03-р сарын 03-ны өдрийн 01 тоот хурлын тогтоолыг хавсаргав.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

НУТГИЙН ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ,

УВС АЙМАГ, БӨХМӨРӨН СУМЫН  
ЗАСАГ ДАРГА .....  
(Т. ТӨРТӨГТӨХ)

АШИГТ МАЛТМАЛЫН  
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ

ХОТГОР ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ .....  
(З. КАДИРХАН)

Хотгор ХХК-тай байгуулсан гэрээний хавсралт

Хамтын ажиллагааны гэрээнд хүрээнд 2019 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт		Хэрэгжүүлэх талууд		Үр дүн		Санхүүжүүлэгч		Төсөв/ зардал		Хэрэгжих цаг, хугацаа	
№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх талууд	Төсөвт тээвэр зардалаа хэмнэнэ.	Тухайн баг өвс тэжээлийн фонтоотой болно.	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК
1	Төсөвт байгууллагын үйлчилгээнд пургон машинтай болох	ЗДТГ	байгууллагууд шатахууны зардалаа хэмнэнэ.	байгаа ашиглах боломжтой болно.	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК
2	Хар-алтат багийн хуучин конторыг засварлах, өвс тэжээлийн фонд бий болгох	ЗДТГ			Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК
3	Хар-алтат багийн төвийн баруун талын худагт цахилгааны шугам татаж ажилд оруулах	ЗДТГ			Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК
4	Хөх эргийн 2 талын орц засах	ЗДТГ			Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК
5	Хилийн заставд мотоцикль авч өгсөн	ЗДТГ			Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК
6	Нүүрс өгөх нийт 1100 тн олгоно үүнээс: Айл өрхд 1020 тн, Аж ахуйн нэгжид 30 тн, Хилийн заставд 50 тн /шигшүүр/	ЗДТГ			Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК
7	Байгаль орчны ажилтны цалин	ЗДТГ			Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК
8	Хүүхдийн сургалтын төлбөр	ЗДТГ			Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК	Хотгор ХХК
Нийт төсөв										83.120.000	

Хотгор ХХК-ын гүйцэтгэх захирал ..... 3 Кадирхан

